**УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ**
**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ**
**ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ**

Салбар: Уул уурхай

Мэргэжлийн индекс: 3257-22

# Дипломын ажил

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ**
**2017 ОН**

**УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ**
**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ**
**ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ**

Салбар: Уул уурхай

Мэргэжлийн индекс: 3257-22 .

# Дипломын ажил

Сэдэв: ЭШ 10/70 Экскаваторын бүтээлийн сайжруулалт

Гүйцэтгэсэн: УАТ 3А- ангийн оюутан Т.Тэмүүжин

Удирдагч: Техникийн ухааны магистр Т.Цолмон

95%

Хамгаалалтанд орохыг зөвшөөрсөн:

Сургалтын албаны менежер: Л. Ганчимэг

Сургалтын арга зүйч: Ц.Мягмарсүрэн

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ**
**2017 ОН**

# АГУУЛГА

ОРШИЛ.....3

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АШИГТ МАЛТМАЛЫН ОРД БА БҮС НУТГИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ ..... 4

1.1 Бүс нутгийн тухай ерөнхий мэдээлэл.....4

1.2. Ордын уул геологийн тогтоц.....5

ХОЁРДУГААР БҮЛЭГ. УУЛЫН АЖЛЫН ОДООГИЙН БАЙДАЛ БА ҮНДСЭН ДҮГНЭЛТ.....6

2.1. Уурхайн ашиглалтын төслийн шийдлүүд.....6

2.2. Уурхайн уулын ажлын байдал, Уулын 1-р хэсэг.....7

2.2.1. Чулуулгийг бэлтгэх процесс.....7

2.2.2. Чулуулгийг ухаж ачих процесс.....7

2.2.3. Тээвэрлэх процесс.....9

2.2.4. Овоолох процесс.....10

2.2.5. Уулын тоног төхөөрөмжийн үзүүлэлт.....13

2.2.6. Нүүрсний чанар.....15

2.2.7. Ус шүүрүүлэлт.....16

2.2.8. Өрөмдлөг тэсэлгээний ажил.....17

2.2.8.1. Тэсэлгээний ажлын зардал.....17

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ, ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТ.....24

3.1. Ерөнхий байдал.....24

3.2. Нөхөн сэргуултийн ажлын технологи, механикжуулалт.....24

3.3. Нөхөн сэргээлтийн ажлын зохион байгуулалт.....25

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

4.1. Уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг шаардлага.....26

4.2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа.....27

4.3. Уурхайн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ.....28

4.4. Ажлын байрны аюулгүй ажиллагааны шаардлага.....28

ТАВДУГААР БҮЛЭГ. ТӨСӨВ, ЭДИЙН ЗАСАГ, УУЛЫН 1-Р ХЭСЭГ.....30

5.1. Эдийн засгийн үзүүлэлт.....30

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ТУСГАЙ ХЭСЭГ.....38

Дүгнэлт.....42

Ашигласан ном зүй.....43

## ОРШИЛ

Багануурын нүүрсний орд газар нь Улаанбаатар хотоос зүүн тийш 130.0 км зайтай Хэнтийн уулархаг мужийн зүүн өмнөд хэсэгт Хэрлэн голын баруун эргийн дагуу оршдог. Орд газрын гадаргын өндөршилт нь далайн түвшингээс дээш 1332.9-1376.3 м хооронд хэлбэлздэг.Нүүрсний орд нь зүүн хойноос баруун урагш чиглэсэн суналын дагуу уртаараа 12 км, өргөнөөрөө 4-5 км талбай эзэлж мульд маягаар тогтсон үндсэн 3-н нүүрсний давхаргаас бүрдсэн эрчим хүчний зориулалттай Б2 маркын нүүрсэнд хамаарна. Ордын нийт нөөцийг 1977 оны хайгуулаар тогтоосон.

Үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал 4.0 сая.тн бөгөөд дотоодын хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээнээс хамаарч 3.6-3.8 сая.тн нүүрсийг олборлож 16.0-18.0 сая шоо метр хөрс хуулж, авто тээвэртэй болон тээвэргүй хосолсон ашиглалтын системээр олборлолт явуулдаг. Монгол улсын нүүрсний хэрэгцээний 60%, төвийн бүсийн нүүрсний хэрэгцээний 70 гаруй хувийг дангаараа хангаж ирсэн. 0-200 мм бутармагтай нүүрсийг вагон болон бусад жижиг авто тээврийн хэрэгслээр хэрэглэгчдэд нийлүүлдэг.

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АШИГТ МАЛТМАЛЫН ОРД БА БҮС НУТГИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

## 1.1. Бүс нутгийн тухай ерөнхий мэдээлэл

Уурхайн байршил

Багануурын нүүрсний орд газар нь Улаанбаатар хотоос зүүн тийш 130.0 км зайтай Хэнтийн уулархаг мужийн зүүн өмнөд хэсэгт Хэрлэн голын баруун эргийн дагуу оршдог. Орд газрын гадаргын өндөршилт нь далайн түвшингээсдээш 1332.9-1376.3 м хооронд хэлбэлздэг.

Зураг 1.Багануур уурхайн нүүрсний ордын газар зүйн байршил

Уур амьсгал

Төслийн талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, хур тунадасны хэмжээ жилд 100- 150 мм хүрэх ба үүний 60-70% нь зуны 6-8 дугаар саруудад ордог. Жилийн хамгийн өндөр агаарын температур нь 6-7 дугаар саруудад 35-400 с хүрдэг бол өвлийн хамгийн бага температур нь 12-1 дүгээр саруудад -35-400 с хүрнэ. Цасны дундаж зузаан нь 10- 20 см,

хүнгарласан хэсэгтээ хамгийн ихдээ 2 м хүрнэ. Салхи нь ихэвчлэн баруун хойд болон зүүн хойд чиглэлээс дунджаар 7 м/сек хурдтай салхилна.

### 1.2 . Ордын үүл геологийн нөхцөл

Нүүрсний орд нь зүүн хойноос баруун урагш чиглэсэн суналын дагуу уртаараа 12 км, өргөнөөрөө 4-5 км талбай эзэлж мульд маягаар тогтсон үндсэн 3-н нүүрсний давхаргаас бүрдсэн эрчим хүчний зориулалттай Б2 маркын нүүрсэнд хамаарна. Ордын нийт нөөцийг 1977 оны хайгуулаар тогтоосон.

| | |
|---|---|
| Эзэмшил газрын хэмжээ | 3164.4 га |
| Ордын нүүрсний нөөц | 812.0 сая.тонн (2015-оны 1 сарын 1 ны байдлаар) |
| Ордын талбай | 12*4 км |
| Нүүрсний давхаргын тоо | 3 |
| Давхаргын уналтын өнцөг | 8-20 хэм |
| Хөрсний дундаж зузаан | 80 метр |
| Нүүрсний үнслэг | 12-17% |
| Нүүрсний чийглэг | 28-33% |
| Нүүрсний хүхрийн агуулга | 0.3-0.5% |
| Нүүрсний илчлэг | 3200-3600ккал/кг |
| Нүүрсний хувийн жин | 1.23-1.31 тн/м3 |
| Хөрсний хувийн жин | 1.95-2.25 тн/м3 |
| Гүний усны ундрага | 1100м3/цаг |

Хүснэгт 1.Ордын байдал

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. УУЛЫН АЖЛЫН ОДООГИЙН БАЙДАЛ БА ҮНДСЭН ДҮГНЭЛТ

### 2.1. Уурхайн ашиглалтын төслийн шийдлүүд

Баганаар уурхайн нүүрсний ордыг ил аргаар олборлох техник эдийн засгийн үндэслэл нь жилд 4 сая.тн нүүрс олборлохоор хийгджээ. Дотоодын хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээнээс хамаарч 3.6-3.8 сая.тн нүүрсийг олборлож 16.0-18.0 сая шоо метр хөрс хуулж, авто тээвэртэй болон тээвэргүй хосолсон ашиглалтын системээр олборлолт явуулдаг. Монгол улсын нүүрсний хэрэгцээний 60%, төвийн бүсийн нүүрсний хэрэгцээний 70 гаруй хувийг дангаараа хангаж ирсэн. 0-200 мм бутармагтай нүүрсийг вагон болон бусад жижиг авто тээврийн хэрэгслээр хэрэглэгчдэд нийлүүлдэг. Баганаурын нүүрс нь өөрийн физик, хими шинж чанараараа зөвхөн эрчим хүчний зориулалтаар ашиглагдах төдийгүй дахин боловсруулалт хийгдэн шатдаг хий, түлш, шингэн ба шахмал түлш, бусад химийн үйлдвэрлэлийн түүхий эд болох бүрэн боломжтой нь судалгаагаар батлагдсан. Байгуулагдсанаасаа хойш анхны төсөл болох тухайн үеийн ЗХУ-ын ГИПРОШАХТ институтын боловсруулсан төслийг мөрдлөг болгон ажиллаж байсан. 1995 оноос техник технологийн шинэчлэл хийх, хөрс хуулалтын хоцрогдлыг арилгах, нүүрс олборлолтыг тогтворжуулах зорилгоор “Монгол нүүрс” төслийг хэрэгжүүлэн уурхайн өмнө тулгарч байсан олон хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэн амжилттай ажиллаж байна.

### 2.2. Уурхайн уулын ажлын байдал, Уулын 1-р хэсэг

Монгол улсын нүүрсний хэрэгцээний 60%, төвийн бүсийн нүүрсний хэрэгцээний 70 гаруй хувийг дангаараа хангаж ирсэн.Жилд дотоодын хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээнээс хамаарч 3.6-3.8 сая.тн нүүрсийг олборлож 16.0-18.0 сая шоо метр хөрс хуулж байнаа.

**Уулын тоног төхөөрөмжүүд**

| Тоног төхөөрөмжийн нэр | Тоо хэмжээ | Шанаганы багтаамж /м3/ | Сумны урт /м/ | Жилд хэрэглэх цахилгаан эрчим хүч /кВт, цаг/ | Жин /тн/ |
|---|---|---|---|---|---|
| ЭШ 20/90 | 1 ш | 20 | 90 | 3300 | 1740 |
| ЭШ 15/90 | 1 ш | 15 | 90 | 3300 | 1600 |
| ЭШ 13/50 | 1 ш | 13 | 50 | 1500 | 880 |
| ЭШ 10/70 | 1 ш | 10 | 70 | 1500 | 880 |
| ЭКГ 4у | 1 ш | 4 | 16 | 880 | 360 |
| ЭКГ 10и | 1 ш | 12,5 | 12 | 880 | 410 |

| Тоног төхөөрөмжийн нэр | Тоо хэмжээ | Шанаганы багтаамж /м3/ | Сумны урт /м/ | Жилд хэрэглэх цахилгаан эрчим хүч /кВт, цаг/ | Жин /тн/ |
|---|---|---|---|---|---|
| ЭКГ 8и | 4 ш | 8 | 12 | 880 | 360 |
| ЭКГ 5а | 4 ш | 5 | 7,8 | 350 | 193 |

### 2.2.1. Чулуулгийг бэлтгэх процесс

Тус онуудад ашиглалт явуулсан хэсгийн хөрсний чулуулаг нь экскавацлагдах шинж чанараараа урьдчилан сийрэгжүүлэлт хийх шаардлагагүйгээр ухаж ачих боломжтой чулуулаг юм. Өрөмдлөг тэсэлгээ хийх ажил нь +730-р түвшинд чулуулгийн бат бөхийн коэффициент проф. М.М.Протодъяконовын ангиллаар 3-6, нүүрсэнд өвлийн улиралд 2-4 болж байгаа нь уурхайн хүчин чадал нэмэгдэж гүн ихэссэнтэй холбоотой ба хөрс, нүүрсийг өрөмдлөг тэсэлгээний аргаар сийрэгжүүлж ухаж ачих процесст бэлтгэнэ.

### 2.2.2. Чулуулгийг ухаж ачих процесс

Хөрс хуулалтан дээр ЭШ 10/70 №35, ЭШ 10/70 №:50, ЭШ 15/90, авто хөрс хуулалтанд ЭКГ 8и, ЭКГ 10и ажиллаж байгаа бол нүүрс олборлолтон дээр ЭКГ 5А №1426, ЭКГ 5А №1581 болон жижиг гидр экскаваторууд ажиллаж байнаа.

Хүснэгт 3. ЭШ 10/70 техникийн үзүүлэлт

| № | Үзүүлэлт | |
|---|---|---|
| 1 | Утгуурын багтаамж,м3 | 10 |
| 2 | Хөдөлгүүрийн чадал,квт | 1460 |
| 3 | Утгалтын хамгийн их гүн,м | 30 |
| 4 | Утгалтын хамгийн их радиус,м | 1.9 |
| 5 | Асгалтын хамгийн их өндөр,м | 11 |
| 6 | Хөдөлгөөний хурд,км/цаг | 0.2 |
| 7 | Масс,тн | 767 |



Хүснэгт 4. ЭШ 15/90 техникийн үзүүлэлт

| № | Үзүүлэлт | |
|---|---|---|
| 1 | Утгуурын багтаамж,м3 | 15 |
| 2 | Хөдөлгүүрийн чадал,квт | 1600 |
| 3 | Утгалтын хамгийн их гүн,м | 40 |
| 4 | Утгалтын хамгийн их радиус,м | 76.5 |
| 5 | Асгалтын хамгийн их өндөр,м | 32 |
| 6 | Хөдөлгөөний хурд,км/цаг | 0.7 |
| 7 | Масс,тн | 1160 |

Хүснэгт 5. ЭКГ 8и техникийн үзүүлэлт

| № | Үзүүлэлт | |
|---|---|---|
| 1 | Утгуурын багтаамж,м3 | 8 |
| 2 | Хөдөлгүүрийн чадал,квт | 630 |
| 3 | Утгалтын хамгийн их гүн,м | 12.5 |
| 4 | Утгалтын хамгийн их радиус,м | 18.2 |
| 5 | Асгалтын хамгийн их өндөр,м | 9.2 |
| 6 | Хөдөлгөөний хурд,км/цаг | 0.45 |
| 7 | Масс,тн | 370 |

Хүснэгт 6. ЭКГ 10и техникийн үзүүлэлт

| № | Үзүүлэлт | |
|---|---|---|
| 1 | Утгуурын багтаамж,м3 | 10 |
| 2 | Хөдөлгүүрийн чадал,квт | 630 |
| 3 | Утгалтын хамгийн их гүн,м | 13.5 |
| 4 | Утгалтын хамгийн их радиус,м | 18.4 |
| 5 | Асгалтын хамгийн их өндөр,м | 8.6 |
| 6 | Хөдөлгөөний хурд,км/цаг | 0.42 |
| 7 | Масс,тн | 395 |

### 2.2.3. Тээвэрлэх процесс

Уул уурхайн үйлдвэрт хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүд төрөл бүрийн ачааг зөөж шилжүүлэх зорилгоор хэрэглэгдэнэ.Уурхайн тээврийг гадаад, дотоод, үйлдвэрийн тээвэр гэж ангилна.

Гадаад тээвэр нь ашигт малтмал, баяжмал зэргийг шууд хэрэглэгчдэд хүргэх зориулалттай.

Дотоод тээвэр нь технологийн дамжлага, баяжуулах үйлдвэр зэрэг цех, үйлдвэрүүдийн технологийн хувьд ялгаатай цэгүүдэд ашигт малтмал, баяжмалыг тээвэрлэнэ.

Хөрсийг KOMATSU HD-785 болон CAT-777D маркийн автосамосвалуудаар 1,2 км зайд тээвэрлэж 1 болон 2-р овоолгод хурааж байна. Нүүрсийг CAT 777D болон KOMATSU HD-785 маркийн автосамосвалаар дунджаар 1,2 км зайд тээвэрлэж нүүрс шигшүүрийн талбайд хурааж байна.

Хүснэгт 7. KOMATSU HD-785 автосамосвалын техникийн үзүүлэлт

| № | Үзүүлэлт | |
|---|---|---|
| 1 | Даац, кг | 78000 |
| 2 | Өөрийн масс, кг | 60400 |
| 3 | Тэвшний багтаамж, м3 | 53/69,3 |
| 4 | Хөдөлгүүрийн чадал, квт | 280 |
| 5 | Дундаж хурд, км/цаг | 50 |
| 6 | Бодит жин, кг | 25750 |

Хүснэгт 8. CAT-777D автосамосвалын техникийн үзүүлэлт

| № | Үзүүлэлт | |
|---|---|---|
| 1 | Даац/тн/, Шанага/м3/ | 91 |
| 2 | Өөрийн масс, кг | 61800 |
| 3 | Тэвшний багтаамж, м3 | 36,4/51,5 |
| 4 | Хөдөлгүүрийн чадал, квт | 1000 |
| 5 | Дундаж хурд, км/цаг | 60 |
| 6 | Бодит жин, кг | 64359 |

### 2.2.4. Овоолох процесс

Уурхайн баруун хэсгийн ажлын талын хөрсийг “Хойд” гадаад траншейг ашиглан тээвэрлэж хөрсний 2-р овоолгод, уурхайн зүүн хэсгийн ажлын талын хөрсийг “Зүүн хойд” дотоод траншейг ашиглан тээвэрлэж хөрсний 1-р овоолгод хурааж байна. Овоолгын хил хязгаар, хэлбэр хэмжээг уулын ажлын урт хугацааны төлөвлөлтөнд тусгасны дагуу өндрийн хязгаарыг +812-ийн түвшинд барьж зөвхөн доод ярусыг үүсгэн хөрсний овоолгыг үүсгэж байна. Бульдозерын овоолгод хөрс хүлээн авахад KOMATSU D375A-2 гинжит бульдозер ажиллаж, овоолгын хэлбэржүүлэлт, тэгшилгээ гэх мэт бусад туслах чанарын ажлуудыг уурхайгаас нэмэлт грейдер татах байдлаар хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 9.KOMATSU D375A-2 техникийн үзүүлэлт

| № | Үзүүлэлт | |
|---|---|---|
| 1 | Хөдөлгүүрийн хүчин чадал | 525 |
| 2 | Даац/тн/, Шанага/м3/ | 26 |
| 3 | Дээд хурд. Км/цаг | 12 |
| 4 | Бодит жин, кг | 68900 |

Уулын 1-х хэсэг уулын ажил




График 1. Уулын хэсгийн ажил

График 2. Нүүрс гаргалт /2007-оос 2016 он/

График 1. Хөрс хуулалт/2007-оос 2016 он/



График 3. Уулын цулаар/2007-оос 2016 он/




**2.2.5. Уулын тоног төхөөрөмжийн үзүүлэлт**

| № | Тоног төхөөрөмж | Төрөл | Х.Нэгж | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | ЭШ 15/90 №137 | Хөрс | м.м$^3$ | 410.0 | 914.1 | 223% |
| | | А.Хөрс | м.м$^3$ | 1360.0 | 1448.6 | 107% |
| | | Шидэлт | м.м$^3$ | 900.0 | 1063.6 | 118% |
| | | И.Ажил | м.м$^3$ | 130.0 | 140.5 | 108% |
| | | У.Цул | м.м$^3$ | 2800.0 | 3568.2 | 127% |
| 2 | ЭШ 10/70 №50 | Хөрс | м.м$^3$ | 1010.0 | 873.5 | 86% |
| | | Шидэлт | м.м$^3$ | 460.0 | 553.5 | 120% |
| | | И.Ажил | м.м$^3$ | 95.0 | 71.5 | 75% |
| | | У.Цул | м.м$^3$ | 1560.0 | 1498.5 | 96% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | ЭШ 10/70 №35 | Хөрс | $м.м^3$ | 460.0 | 904.0 | 197% |
| | | А.Хөрс | $м.м^3$ | 375.0 | 471.1 | 126% |
| | | Шидэлт | $м.м^3$ | 710.0 | 734.3 | 103% |
| | | И.Ажил | $м.м^3$ | 120.0 | 121.0 | 101% |
| | | У.Цул | $м.м^3$ | 1600.0 | 2220.4 | 139% |
| 4 | ЭКГ 10И №33 | Авто хөрс | $м.м^3$ | 1550.0 | 1374.1 | 89% |
| 5 | ЭКГ 8И №2250 | Авто хөрс | $м.м^3$ | 1530.0 | 1117.6 | 73% |
| 6 | ЭКГ 4У №323 | Авто хөрс | $м.м^3$ | 940.0 | 1086.5 | 116% |
| 7 | ЭКГ 5А №1426 | Гаргалт | м.тн | 645.0 | 700.8 | 109% |
| 8 | ЭКГ 5А №1581 | Гаргалт | м.тн | 670.0 | 782.9 | 117% |
| 9 | СБР 160 №07 | Өрөмдлөг | у.м | 35234 | 44353.5 | 126% |
| 10 | СБР 160 №09 | Өрөмдлөг | у.м | 50032.4 | 58457 | 117% |

Хүснэгт 11 . Уулын тоног төхөөрөмжийн үзүүлэлт

Хүснэгт 12. Уулын тоног төхөөрөмжийн бүтээлийг өмнөх жилүүдтэй харьцуулбал, /мян.м3/

| № | Тоног төхөөрөмж | Ажлын төрөл | Хэмжих нэгж | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | Зөрүү, % |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ЭШ-15/90 №137 | У/цул | мян.м3 | 2693.4 | 2231.8 | 3412.9 | 3237.9 | 2578.3 | 3568.2 | 38.4 |
| 2 | ЭШ-10/70 №50 | У/цул | мян.м3 | 1731.3 | 1549 | 1978.8 | 1853.9 | 1942.0 | 1498.5 | 29.5 |
| 3 | ЭШ-13/50 №35 | У/цул | мян.м3 | 1522.1 | 2065 | 1887.3 | 1568.9 | 2011.9 | 2220.4 | 10.4 |
| 4 | ЭКГ-10И №33 | У/цул | мян.м3 | 1267.7 | 1003 | 1743.0 | 1310.0 | 1446.1 | 1374.1 | 5.2 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | ЭКГ- 8И №2250 | У/цул | мян.м3 | 1016.5 | 873 | 801.3 | 1208.6 | 1041.3 | 1117.6 | 7.3 |
| 6 | ЭКГ-4у №323 | У/цул | мян.м3 | 771.5 | 710 | 1263.7 | 1127.9 | 1201.8 | 1086.5 | 10.5 |
| 7 | ЭКГ-5А №1426 | У/цул | мян.тн | 636.1 | 559 | 498.3 | 646.7 | 619.3 | 700.8 | 13.2 |
| 8 | ЭКГ-5А №1581 | У/цул | мян.тн | 623.2 | 386.2 | 858.7 | 722.2 | 562.5 | 782.9 | 39.2 |
| 9 | Өрөм | у/метр | метр | 84.5 | 88.4 | 79.1 | 100.0 | 101.3 | 102.9 | 1.6 |

Экскаваторын ээлжийн бүтээл: ЭШ 10/70

1. $Q_{ээ} = Q_{эц} \cdot T_э \cdot K_{эц} \cdot K_{ма} \cdot K_{тх} = 450 \cdot 8 \cdot 0.8 \cdot 0.95 \cdot 0.9 = 2466 м^3/ээлж$

$T_э$ -Ээлжийн үргэлжлэх хугацаа

$K_{эц}$ -Ээлжийн цаг ашиглалтын коэффициент

$K_{ма}$ - Экскаваторын мөргөцөг дэх ахилт шилжилтийг тооцох коэффициент,

$K_{ма} = 0.92 \div 0.95$

$K_{тх}$ -Экскаваторыг тээврээр хангах нөхцлийг тооцох коэффициент, $K_{тх} < 1$

2.Экскаваторын хоногийн бүтээл:

$Q_{эх} = n_{ээ} \cdot Q_{ээ} = 3 \cdot 2466 = 7400 м^3/хоног$

$n_{үй}$ -Экскаваторын хоногт ажиллах ээлжийн тоо

3.Экскаваторын жилийн бүтээл:

$Q_{эж} = Q_{эх} \cdot N_ж = 7400 \cdot 300 = 2220000 м^3/жил$

$N_ж$ - Экскаваторын жилд ажиллах хоногийн тоо

### 2.2.6. Нүүрсний чанар

Нүүрсний чанарт онцгой анхаарч таазны цэвэрлэгээ, контровка таталт, нүүрсний хананы цэвэрлэгээ болон нүүрс гаргалтын экскаваторууд бохирдолгүй нүүрс ачих зэрэгт хяналт тавьж ажилласны үр дүнд нүүрсний дундаж илчлэг 3491.5 ккал/кг, чийглэг 34.5%, үнслэг 10.1%-тай гарсан байна.

Нүүрсний хаягдлыг бууруулах зорилгоор прослойктой/завсрын хөрс/ нүүрсийг тусдаа овоолгод буулгаж ялгуулах, ул таазны цэвэрлэгээг сайн хийх, гидро экскаватораар хөрсний үеийг ялгах зэрэг ажлыг зохион байгуулж ажилласан.

| № | Үзүүлэлт | Илчлэг, ккал/кг | Чийглэг, % | Үнслэг, % |
|---|---|---|---|---|
| 1 | 2011 | 3478 | 29.6 | 8.9 |
| 2 | 2012 | 3490 | 30.1 | 8.5 |
| 3 | 2013 | 3492 | 36.3 | 9.1 |
| 4 | 2014 | 3493 | 32.6 | 9.1 |
| 6 | 2015 | 3504 | 34.5 | 9.1 |
| 7 | 2016 | 3491.5 | 34.5 | 10.1 |

Хүснэгт 13.Нүүрсний чанар өмнөх онуудтай харьцуулалт

### 2.2.7. Ус шүүрүүлэлт

2016 онд ашиглалтын 4, 6-р амнуудад 4-р сараас 11-р сарын хооронд ил зумпф ажилуулж усан доороос нийт 11.2 мянган тн нүүрс олборлосон байна. 4-р амны зумпфыг ам талын нүүрсийг авах, усны түвшин барих зорилгоор ажиллуулсан.

6-р амны зумпфны насос 9, 10 сард хэвийн ажиллаж чадаагүй. Учир нь насосны гэмтэлтэй, зам гаргах ажил удааширсан зэрэг шалтгаанаар 6-р амнаас нүүрсийг бүрэн авч чадаагүй.

Зураг 2. Ил зумпфны ажилласан байдал

### 2.2.8. Өрөмдлөг тэсэлгээний ажил

2016 онд нийт 82 удаагийн тэсэлгээний ажлыг ХАБЭА-н ямар нэг зөрчил, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэлгүй хийсэн бөгөөд тэсэлгээнээс хамаарсан тоног төхөөрөмжийн сул зогсолт, ажлын фронтгүй цаг гаргаагүй, чулуулгийн бутлагдалын хэмжээг жил бүр бууруулан ажиллаж байна. Тээвэртэй хөрсний доголд ажлын бүс талд габрит их гарч байгаад анхаарч, өрмийн машинч нарт сургалт явуулж өрөмдлөг хийлгэснээр ажлын бүс талын габритыг бууруулж дараа дараагийн доголуудын түвшингийн ялгааг арилгах нөхцлийг бүрдүүлж ажилласан.

Өрөмдлөгийн ажлын паспорт

**( Алхагч экскаватрын өндөр догол )**

**Өрөмдлөг хийх ажлын дэс дараалал, анхаарах зүйл:**

1. Өрөмдлөг хийхээс өмнө талбайг засуулж хүлээн авна.
2. Өрөмдлөгийн талбайн үзэгдэх хийж өрөмдлөг хийхэд ямар нэгэн аюул, саадтай зүйлгүйг нягтална.
3. Өрөмдөлдөх цооногуудын байрлалыг тогтоож цаа тавина.
4. Өрөмдлөг хийхээр тухайн блокод өрмийн машиныг шилжүүлэн авчирч байрлуулах үед догол мөргөгчийн ирмэгээс аюулгүй зайд, тухайн ирмэгт перпендикуляр /өрмийн машины ирмэгт хөндлөн/ байрлаатайгаар байрлуулна.
5. Өрөмдлөгийн ажлын явцад догол мөргөгчийн ирмэгт ан цав, сарвуу үүссэн тохиолдолд арилгах арга хэмжээг авсны дараа ажлаа үргэлжлүүлнэ.
6. Тухайн цооногийг өрөмдөж дууссан, өрмийн машин нь цооногийн шороолт хийхэд аюулгүй зайд гарч дараагийн цооногт шилжин ажиллах үед цооногийн шороолтыг машинчийн жаврын дагуу өрмийн туслах машинч хийж гүйцэтгэнэ.
7. Өрөмдөх талбайн бүх цооногийг өрөмдөж шороолт хийсний дараа өрмийн машинч нь өрөмдлөгийн блокыг хэсгийн инженер, ОТ-ний инженерт хүлээлгэн өгнө.
8. ХХАА-ны холбогдох дүрэм, журам,заавраг чанд мөрдөж ажиллах.
9. Паспортод тусгагдсан параметр, хэмжээг мөрдөж болгох.
10. Мөргөгчийн ирмэгээс 6м-н зайд (хүн ба техник) байрлаж өрөмдөнө.
11. Цооногийн торны хэмжээ 8х7 метр байх ба улирлын хөдлөлтөөс хамаарч туслах цооног өрөмдөнө. /11-03-р сарын хооронд/
12. Цооногийн гүн 22-32м, нүүрсний тал хүртэл өрөмдөх, цооногийн диаметр 200мм байна.

ПЛАН М1:500

ЗҮСЭЛТ Г–Г М1:1000

Баганууд нүүрсний уурхай

Таних тэмдэг:
Үндсэн цооног /хүн цооног/
Туслах цооног /богино цооног/

| Үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Тэслэх уулын цулын төлөвлөгөө | | Тэсэлсэн уулын цул | | Зөрүү | | УТТ-н Гүйцэтгэл /хөрс м.м3, нүүрс м.тн/ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2015 | 2016 | 2015 | 2016 | 2015 | 2016 | 2015 | 2016 |
| ЭШ-15/90 №137 | мян.м$^3$ | 1482.0 | 1370.0 | 1432.2 | 482.6 | -49.8 | -887.4 | 1962.4 | 2362.7 |
| ЭШ-10/70 №50 | мян.м$^3$ | 900.0 | 834.0 | 974.9 | 864.1 | 74.9 | 30.1 | 1156.1 | 873.5 |
| ЭШ-10/70 №35 | мян.м$^3$ | 660.0 | 715.0 | 794.8 | 433.2 | 134.8 | -281.8 | 1144.6 | 1375 |
| ЭКГ-10И №33 | мян.м$^3$ | 1.043 | 955.0 | 893.8 | 1002.5 | -149.2 | 47.5 | 1446.1 | 1374.1 |
| ЭКГ-8И №2250 | мян.м$^3$ | 1020.0 | 850.0 | 808.0 | 1358.9 | -212.0 | 508.9 | 1041.3 | 1117.6 |
| ЭКГ-4У №323 | мян.м$^3$ | 697.0 | 605.0 | 815.4 | 761.8 | 118.4 | 156.8 | 1201.8 | 1086.5 |
| ЭКГ-5А №1581 | мян.м$^3$ | 128.9 | 221.0 | 73.8 | 0 | -55.1 | -221.0 | 619.3 | 782.9 |
| ЭКГ-5А №1426 | мян.м$^3$ | 171.9 | 221 | 146.8 | 68.8 | -25.1 | -152.2 | 562.5 | 700.8 |

Хүснэгт 14. Өрөмдлөг тэсэлгээний ажил

Өрөмдлөг тэсэлгээний ажлын тооцоо:СБР-160 №4

1. Өрөмдлөгийн механик хурд :

$$V_{мех} = \frac{2.5 \cdot 10^{-2} \cdot P \cdot n}{\Pi_в \cdot d_x^2}$$

$P$ - өрмийн машины тэнхлэгийн даралт,кН

n – хошууны эргэлтийн давтамж, мин $^{-1}$

$\Pi_в$ Чулуулгийг өрөмдөх зэрэг

$d_x$ -өрмийн хошууны диаметр, мм

$$V_{мех} = \frac{2.5 \cdot 10^{-2} \cdot 80 \cdot 1.7}{15 \cdot 0.2445^2} = 4.5 м/цаг$$

2. Өрмийн машины ээлжийн бүтээл:

$$Q_{өэ} = \frac{T_э - T_з}{t_y + t_m} = \frac{8 - 0.8}{0.22 + 0.03} = 28.8 м/ээлж$$

$T_э$ - ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг

$T_з$ -ажлын ээлжинд ногдох завсарлагууд, цаг

$T_з = t_{эх} + t_{зз}$

$t_{эх}$ -ээлж хүлээлцэх хугацаа, цаг

$t_{зз}$ -ээлжийн хугацаанд зөвшөөрөгдөх завсарлага, цаг

$t_{эх} + t_{зз} \approx 0.2 \div 0.8 цаг$

$t_y$ , $t_T$ -1 метр цооног өрөмдөх үндсэн ба туслах ажлын хугацаа, цаг

$t_y = 1/V_{мех} = 1/4.5 = 0.22 цаг$

3. Өрмийн машины хоногийн бүтээл:

$$Q_{өх} = n_{өэ} * Q_{өэ} = 3 * 28.8 = 86.4 м/хоног$$

$n_{өэ}$-хоног дахь ээлжийн тоо

4. Өрмийн машины жилийн бүтээл:

$Q_{өж} = N_{өж} * Q_{өх}$=300*86.4=25920м/жил

$N_{өж}$-өрмийн машины жилд ажиллах хоногийн тоо

5. Өрмийн машины жилд гүйцэтгэх ажлын эзэлхүүн:

$Q'_{өж} = Q_{өж} * g$ =25920*53.5=1386720м$^3$/жил

g – 1м цооногоос гарах уулын цул, м$^3$

$$g = \frac{[(n-1)*b + W]*H*a}{n*L} = \frac{[(3-1)*7.6+9]*15*9}{3*17.5} = 53.5 м^3/м$$

6. Шаардлагатай өрмийн машины тоо:

$$N_{өж} = \frac{A_{уц}}{Q'_{өж}} = \frac{29576469}{1386720} = 1.45 \approx 1$$ өрмийн машин

$A_{уц}$-жилд олборлох нийт уулын цулын хэмжээ, м$^3$

$A_{уц} = A'_o + A_x$

$A'_o$- жилд олборлох хүдрийн хэмжээ, $м^3$

$$A'_o = \frac{A_o}{\gamma_x} = \frac{4906200тн}{2.55тн/м^3} = 1924000м^3$$

$\gamma_o$ -хүдрийн нягт, $тн/м^3$

$A_x$ -жилд хуулах хөрсний хэмжээ, $м^3$

$A_X = A'_o * К_x = 1924000*0.676 = 130062м^3$

$К_x$-хөрс хуулалтын коэффициент $К_x$=0.676

$A_{уц} = A'_o + A_x$=1924000+130062=29576469$м^3$

Өрөмдлөгийн ажлын зардал

Өрөмдлөгийн ажлын зардлыг 1м цооногт болон $1м^3$ чулуулагт ногдох зардлын хэлбэрээр тус тус тооцно.

1. Нэг метр цооногт ногдох өрөмдлөгийн ажлын зардал. төг/м

$$З_ө = \frac{Z_{өэ}}{Q_{өж}} + \frac{Y_{өх}}{L_{өх}} = \frac{2214644000}{25920*9} + \frac{2200000}{2300} = 9493 + 956.52 = 10450 \text{ төг/м}$$

$Z_{өэ}$ -Өрмийн машины жилийн ажлын зардал, төг/жил

$Q_{өэ}$ -Өрмийн машины жилийн бүтээл, м/жил

$Z_{өэ} = Z_{цх} + Z_{эх} + Z_{ндш} + Z_м + Z_{эхш} + Z_б$=28.704+1706.2+3.15+274.76+0.48+201.33= 2214.644сая.төг/жил

Zцх-жилийн нийт ажилд ногдох цалин хөлс төг/жил

Zэх-эрчим хүчний зардал төг/жил

Zндш-нийгмийн даатгалын шимтгэл төг/жил

Zм- материалын зардал төг/жил

Z эхш-элэгдэл хорогдлын шимтгэл төг/жил

Z б –болон бусад зардал төг/жил

$Y_{өх}$ -Өрмийн хошууны үнэ төг

$L_{өх}$ -өрмийн хошууны эдэлгээ, м

2. Цалин хөлсний зардал:

Zцх= Zжц+ Zшц=15.456+13.248= 28.704сая.төг/жил

Zжц= Т*Цнэш =2208* 7000=15.456сая.төг

Т- жилд ажиллах цаг

Цнэш-машинистын нэг цагийн тарифт цалин.төг

Цтус-туслах машинистын нэг цагийн тарифт цалин.төг

Zшц=2208*6000=13.248 сая.төг

3. Нийгмийн даатгалын шитгэл:

Нийгмийн даатгалын шимтгэлийг нийт цалингийн 11%-иар тооцно.

Zндш=Zцх*0.11=28.704*0.11=3.15сая.төг/жил

4. Цахилгаан эрчим хүчний зардал:

Zэх=n*$q_{цэ}$*a*Qөж=9*0.44*136.62* *3153825* =1706.26сая.төг/жил

n-паркийн тоо

$q_{цэ}$-Цахилгаан эрчим хүчний хувийн зарцуулалт кВт.цаг/$м^3$

а-Нэг кВт/цаг эрчим хүчний үнэ, төг

Qөж-Өрмийн машины жилийн бүтээл, $м^3$

5. Материалын зардал:

Материалын зардлыг цахилгаан зарцуулалтын мөнгөн дүнгийн 25%-иар авч тооцно.

Zм=Zэх*0.25=1099.044*0.25=274.76 сая.төг/жил

2.2.9.1. Тэсэлгээний ажлын зардал

Тэсэлгээний ажилд 2016 онд алсын зайнаас удирдаж тэслэх багажыг хэрэглэж эхэлсэн ба энэ нь тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагаанд эерэгээр нөлөөлж байна.

| Үзүүлэлтүүд | Тэсэлсэн уулын цул, мян.м3 | | | Зардал, сая.төг | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө | гүйцэтгэл | хувь | төлөвлөгөө | гүйцэтгэл | хувь | зөрүү |
| ЭШ-15/90 №137 | 1370 | 482.6 | 35.0 | 552.3 | 244.8 | 44.3 | -307.5 |
| ЭШ-10/70 №50 | 834 | 864.1 | 103.6 | 336.5 | 320.8 | 95.3 | -15.7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ЭШ-13/50 №35 | 715 | 433.2 | 60.5 | 290.5 | 184.6 | 63.6 | -105.8 |
| ЭКГ-10И №33 | 955 | 1002.5 | 104.9 | 379.0 | 404.6 | 106.8 | 25.6 |
| ЭКГ-8И №2250 | 850 | 1358.9 | 159.8 | 334.8 | 508.0 | 147.3 | 163.2 |
| ЭКГ-4У №323 | 605 | 761.8 | 125.9 | 245.5 | 286.2 | 116.6 | 40.6 |
| ЭКГ-5А №1581 | 221 | 0 | 0 | 72.6 | 0 | 0 | 72.6 |
| ЭКГ-5А №1426 | 221 | 68.8 | 31.0 | 73.3 | 23.8 | 32.5 | -49.5 |
| Уулын 1-р хэсэг | 5771 | 4971.8 | 86.0 | 2294.8 | 1973.1 | 86.0 | -321.7 |

Хүснэгт 15. Тэсэлгээний ажлын зардал

**Тэсэлгээний ажлын параметрийг В.В. Ржевскийн аргачлалаар тодорхойлох**

1. Цооногийн гүн:

$$L_{цо} = \frac{H_д}{\sin\beta} + L_{иө} = \frac{15}{\sin 90^0} + 1{,}6 = 16{,}6 \text{ м}$$

$L_{иө}$-илүү өрөмдлөгийн урт, м

$$L_{иө} = (10-15)d_{цо} = 10 * 0.16 = 1.6м$$

2. Цэнэгийн урт

$$L_{цэ} = L_{цо} - L_m = 16.6 - 3.2 = 13.4м$$

$L_m$-түгжээсний урт

$$L_m = (20-35)d_{цо} = 20 * 0.16 = 3.2м$$

3. 1м цооногийн багтаамж:

$$dц = 0.785 * d^2_{цо} * \Delta = 0.785 * 0.16^2 * 1000 = 20кг$$

$d_{цо}$-цооногийн диаметр, м

$\Delta$-ТБ-ын цэнэглэлтийн нягт, кг/м

4. Нэг цооногт орох ТБ:

$$\frac{\pi * d_{цо}^2}{4} + L_{цэ} * \Delta = \frac{3{,}14 * 0{,}16^2}{4} * 13{,}4 * 1000 = 268кг$$

5. Тэсрэх нөхцлөөр тодорхойлох улны эсэргүүцлийн шугам:

$$W = \sqrt{\frac{\pi * dц^2 * Lц * \Delta}{4 * Нд * m * q_д}} = \sqrt{\frac{3.14 * 0.16^2 * 12.4 * 1000}{4 * 15 * 1.2 * 0.45}} = 3.7м$$

6.Цооног хоорондын зай:

$$a = W * m = 3.7 * 1.2 = 4.44м$$

7.Эгнээ хоорондын зай:

$$b = 0.85 * a = 0.85 * 4.44 = 3.7м$$

8.Нэг удаагын тэсэлгээнд хамрагдах чулуулгийн хэмжээ буюу тэсэлгээний блокийн эзэлхүүн:

$N_{дд}$ -жилд хийх тэсэлгээний тоо $N_{aT} = \frac{365 - 9}{4} \approx 82$

$$V_б = \frac{A_ж}{N_{ат}} = \frac{26290195 * 04}{82} = 128244м^3$$

9.тэсэлгээний блокод хамаарах цооногийн тоо (нэг цооногт ногдох чулуулгийн хэмжээгээр)

$$N_{б1.1} = \frac{V_б}{[(n_{эг} - 1) * b + W] H_д * a} n_{эг} = \frac{128244}{[(3-1) * 8.9 + 3.7] * 15 * 4.44} * 3 = 89 ш$$

10.Нэг метр цооногоос гарах уулын цул,$м^3$

$$g = \frac{[(n-1) * b + W] * H * a}{n * L} = \frac{[(3-1) * 3.7 + 3.7] * 15 * 4.44}{3 * 16.6} = 14{,}84 м^3 / м$$

Тэсэлгээний ажлын параметр

| Үзүүлэлтүүд | В.В.Ржевскийн аргачлалаар |
|---|---|
| Хүдрийн тэслэгдэх категори | Дунд зэрэг |
| Өрмийн хошууны диаметр,мм | 160 |
| Цооногийн диаметр, мм | 160 |
| Улны эсэргүүцлийн шугам, м | 3.7 |
| Илүү өрөмдлөгийн гүн, м | 1.6 |
| Түгжээсний урт, м | 3.2 |
| Цэнэгийн урт, м | 13,4 |
| Цооног хоорондын зай, м | 4,44 |
| Цооногын эгнээ хоорондын зай, м | 3,7 |
| Цооног орох цэнэгийн жин, кг | 268 |
| Тэсэлгээний ажлаар үүсэх нурлын өргөн, м | 31,68 |
| Тэслэх блокийн хэмжээ, $м^3$ | 206197 |
| Блок дахь цооногийн тоо | 148 |
| Цооногийн гүн, м | 16,6 |
| ТБ-н нийт хэмжээ, кг | 21976 |
| Цохилтын долгион хүмүүст аюултай үйлчлэх зай, м | 454 |
| Цохилтын долгион барилга байгууламжид аюултай үйлчлэх зай,м | 908 |

Хүснэгт 17. Тэсэлгээний ажлын параметр

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ, ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТ

### 3.1. Ерөнхий байдал

Баганууурын  нүүрсний уурхайг ашиглах явцад их хэмжээний хөрс хуулалт, нүүрс олборлох ажлууд хийгдэх бөгөөд үүний улмаас уурхайн эргэн тойрны хүрээлэн буй орчин экологид тодорхой хэмжээний сөрөг ба эерэг нөлөөлөл бий болно. Уурхайн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд дараах сөрөг нөлөөллүүд бий болно гэж үзэж байна. Үүнд:

• Уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын үйл ажиллагааны улмаас орчны тоосжилт нэмэгдэх магадлалтай.

• Уурхайн ус шүүрүүлэлтийн шууд нөлөөгөөр хөрсний усны түвшин буурч үүний нөлөөгөөр орчны экосистемд өөрчлөлт орох магадлалтай байна.

• Уурхайн үйл ажиллагааны улмаас 80 орчим гүн ашиглагдсан орон зай, хөрсний 10-30 м өндөр гадаад овоолго үүсэн орчны ландшафтын / "Ландшафт" гэдэг нь тухайн газар нутгийн ургамлан бүрхэвч, гадаргуугийн тогтцоор илэрхийлэгдэх "байгалийн дүр төрх/ хэлбэр дүрсэнд өөрчлөлт гарна

3.2. Нөхөн сэргуултийн ажлын технологи, механикжуулалт

Уурхайн ашиглалтын явцад болон хаалтын нөхөн сэргээлтийн үед эвдэрсэн газрыг нөхөн сэргээх үйл ажиллагаа нь техникийн нөхөн сэргээлт ба биологийн нөхөн сэргээлт гэсэн 2 үндсэн үе шатаар хийгдэнэ. Техникийн нөхөн сэргээлтэнд гадаад овоолгыг тэгшлэх, хэлбэржүүлэх, хажууг налуулах болон шимт хөрсөөр бүрэх, суваг шуудуу татах зэрэг ажлууд орно. Нөхөн сэргээсний дараа тухайн газрыг цаашид ашиглах чиглэлээс хамааруулан хэлбэржүүлэх урт өндөр, налуугийң өнцөг зэрэг хэмжигдэхүүнүүд нь харилцан адилгүй байх бөгөөд үүнтэй уялдан хийгдэх уулын ажлын хэмжээ ч өөр өөр байдаг билээ.

### 3.3. Нөхөн сэргээлтийн ажлын зохион байгуулалт

Овоолгын нөхөн сэргээлт:

Хөрсний овоолгын хажууг 220 болгон хэвгийжүүлсний дараагаар 0,5м хүртлэх зузаан шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлтэнд бэлтгэнэ. Шимт хөрсөөр хучсан овоолгын талбайд өвслөг ургамал тарьж ургамалжуулна.

Уурхайн зам талбайн нөхөн сэргээлт: Уурхайн ашиглалтын явцад эвдэгдсэн зам талбай болох уурхайн тосгон орчмын талбай, дамжуулан ачих байгууламж болон уурхайн зам зэрэг талбайг шимт хөрсөөр хучиж ургамалжуулан биологийн нөхөн сэргээлтийг хийнэ.

Нөхөн сэргээлтийн ургамалжуулалт

Тарих хугацааг сонгон авсан ургамлын төрөл зүйлийн онцлогт тохируулан, тариалах газар нутгийн бүс, цаг уурын нөхцөлтэй уялдуулан дараах байдлаар сонгоно. Ашиглалтын үед

байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлууд Улаан-Овоогийн нүүрсний уурхайн ашиглалтын явцад тухайн жилийн уулын ажлын хэмжээ, өрнөлт, овоолгуудын дүүргэлтүүдээс шалтгаалан жилд хийгдэх байгаль орчны ажлуудын хэмжээ янз бүр байх боловч дараахи ажлуудыг заавал хийх шаардлагатай.

Үүнд:

• Уурхайн ашиглалтын эхний үе шатанд шимт хөрсийг хуулж овоолох ажлыг хийх бөгөөд шимт хөрсний овоолго үүсгэн байгуулна.

• Замын усалгааг тогтмол хийж замаа дагуулан мод тарих, ургамалжуулах ажлыг жил бүр хэрэгжүүлнэ.

